

## Хүний ертөнц яагаад төөрөгдлийн нийгэм бэ?

Агуу сансар ертөнц асар уудам тул ямар ч Бурхад, тэнгэрийн Хаад болон дээд Эзэд үүнээс цаана юу оршдогийг мэддэггүй. Тоо томшгүй олон амь бодиуд байдаг. Агуу орчлон ертөнцийн бүх амь бодиуд, оршин буй ертөнцөө тал бүрээс өөрсдийн орших материаллаг түвшний өнцгөөр хардаг, энэ нь Бурхад ертөнцийг хардаг байдлаас өөрцгүй юм, гагцхүү тэдэнд билиг ухаан, Бурханлаг чадвар байхгүй. Өөрөөр хэлбэл, агуу орчлон ертөнц даяарх амь бодиуд хүн төрөлхтнөөс огт өөр байдаг, хүмүүс өөрсдийн амьдарч буй ертөнцийн үнэнийг харж чаддаггүй; хүрээлэн буй орчныхоо бусад амь бодиудын орших хэлбэрийг харж чаддаггүй; мөн үүнд бодитоор орших зүйлсийн жинхэнэ илрэлийг харж чаддаггүй. Үүний улмаас, хүний сэтгэх байдал болон орчлон ертөнцийн талаарх ойлголт нь явцуу бөгөөд хязгаарлагдмал байдаг. Тиймээс энэ бол "төөрөгдөл"-ийн нийгэм (Гурамсан ертөнцийн анхны бурхад болон бясалгалын хүрээн дэх цөөхөн үзэгдлүүдийг эс тооцвол).

Тэгвэл яагаад ийм байдаг вэ? Учир нь, Агуу сансар ертөнц ба түүнд орших олон тооны орчлон ертөнцийн системүүд бүгд Үүсэх, Тогтворжих, Доройтох, Устах сансрын мөчлөгийн "Устах" эцсийн шатанд хүрсэн явдал юм. Эцсийн сүйрлийн аймшигт задралын үед бүх зүйлс бүрмөсөн устаж, цаашид оршихоо болино, тиймээс Бүтээгч бүх амь бодийг аврахаар шийдсэн.

Агуу сансар ертөнц ба түүний доторх олон тооны орчлон ертөнцүүд сүйрлийн шатанд хүрсэн нь тэдгээрт орших тоо томшгүй олон амь бодиуд - үүнд орчлон ертөнц бүрийн Эзэд, Хаадыг, Бурхдыг оролцуулан Үүсэх, Тогтворжих, Доройтох, Устах урт удаан мөчлөгийн явцад, анх Үүсэх үед байсан шиг тийм сайн биш болсон, өөрөөр хэлбэл урт удаан мөчлөгийн явцад бүгд өөр өөрсдийнхөө орших түвшний шаардлагад нийцэхгүй болсон. Энэ бол аливаа амь бодийн орших явц дахь зайлшгүй зүй тогтол юм.

Бүтээгч амь бодиудыг аврахын тулд Агуу сансар ертөнцийн гадна талд нэгэн ертөнцийг бүтээсэн юм. Энэ нь Агуу сансар ертөнцийн тоо томшгүй олон амь бодиудыг аврахад зориулагдсан бөгөөд үүнийг "Гурамсан ертөнц" гэж нэрлэдэг. Гурамсан ертөнц дотор амь бодиудын оршихуйн гурван давхарга байдаг. Хамгийн доод давхаргад байдаг амь бодиуд огт чадваргүй, билиг ухаан мөхөс, хамгийн их төөрөгдөлд байдаг, мөн хамгийн зовлонтой хэцүү орчинд амьдардаг. Энэ бол хүний ертөнц юм. Хоёр дахь давхаргад байдаг хүмүүс болон амь бодиуд энэ хүн төрөлхтнөөс зөвхөн билиг ухаан

танин мэдэхүйн хувьд давуу, тиймээс тэд зөвхөн хүний ертөнцийн болон өөрсдийн давхаргын байдлыг л харж чаддаг. Хүмүүс тэднийг "тэнгэрлэг оршихуйнууд" эсвэл "хагас бурхад" гэж нэрлэдэг. Дараах дээд давхаргынхан бол өөрсдөөс дооших хоёр давхаргын амь бодиудын байдал болон өөрсдийн давхаргын байдлыг харж чаддаг ба Гурамсан ертөнцдөө тэдний билиг ухаан, танин мэдэхүй нь хамгийн өндөр юм. Хүн төрөлхтөн тэднийг ерөнхийдөө "бурхад" гэж нэрлэдэг. Гэсэн хэдий ч Гурамсан ертөнцийн аль ч амь бодь орчлон ертөнцийн жинхэнэ байдлыг болоод үүнээс дээш орших Бурхдын тэнгэрийн орд, диваажинг харах чадваргүй.

Иймээс хүн төрөлхтөн хамгийн дорд билиг ухаан, танин мэдэхүйтэй бөгөөд аливаа зүйлийн мөн чанарыг харах чадваргүй "төөрөгдөл" амьдардаг. Үүнийг ертөнцийн эцсийн төгсгөл ба устгалын өмнө Бүтээгч бүх амь бодиудыг аврахын тулд бүтээсэн. Мөн хүний нинжин сэтгэл, мөн чанарт түшиглэн амь бодиудыг төөрөгдлийн зовлонг ертөнцөөс гэтэлгэхийн тулд бий болгосон юм. Энэ бол үнэхээр маш хэцүү. Үүсэх, Тогтворжих, Доройтох, Устахын хамгийн эцсийн үед амь бодиуд устгалаас зайлах ганц арга зам бол зөвхөн зовлон зүдүүрийг туулж, үйлийн үрээ арилгаж мөн үүний зэрэгцээ "ирээдүйд" зүй зохистой гэж хүлээн зөвшөөрөгдөх нинжин сэтгэл, мөн чанарыг сахиж чадвал аврагдаж чадна. Сансрын төгсгөлийн мөчлөг ирэхэд, Бүтээгч Агуу сансар ертөнцийн олон тооны Бурхад, Хаад, Эздийг болон, түүнчлэн Агуу сансар ертөнцийн хэсэг бүрийг захирдаг, бүр дээд бурхдыг, аугаа гэгээрэгчдийг дэлхийд бууж ирэн хүн болж төрөхийг зөвшөөрсөн. Гэхдээ, тэдний бүх дээд билиг ухаан, бурханлаг чадварууд нь түгжигддэг. Энэ хамгийн хэцүү орчинд, өөрсдийн чадвар, билиг ухаангүйгээр, бүрэн түгжигдсэн хүний биетэйгээр зовлон зүдүүрийг туулж, нүглийг арилгах явцад зөв ариун бодлыг тээж, нинжин сэтгэл мөн чанараа алдалгүй хадгалж чадвал Бүтээгч болон дээд бурхдаар хүлээн зөвшөөрөгдөж ирээдүйн тавилант байраа олно. Энэ хүний нийгэмд ахин дахин төрөл олох явцдаа нүгэлт үйлийн үрээ аажмаар арилгаж улам их буян хураавал авралд сонгогдох нь гарцаагүй. Сүүлчийн ертөнцийн төгсгөлд аврал нээгдэх үед Бүтээгч тэднийг шинэ орчлон ертөнцөд аваачих нь зайлшгүй. Тэгэхээр, "төөрөгдөл"-ийн байдалд хүн төрөлхтний амьдарч, оршин буй нийгэм нь Бүтээгч амь бодиудыг аврахын тулд бүтээсэн онцгой нийгэм юм. Тийм ч учраас хүн аль нэгэн амь бодиос энэ төөрөгдлийг эвдэж өгөхийг гуйх нь нэмэргүй юм. Энэхүү орчлонгийн болон дээд орчлонгийн ямар ч амь бодь авралын тулд хийсэн энэ зохицуулалтыг эвдэж зүрхлэхгүй.

Хүний ертөнцөд, Бурханд итгэхийг мухар сүсэг гэж үздэг хүмүүс үргэлж байдаг. Тиймээс зарим нь зөвхөн харж байгаа зүйлдээ итгэнэ, харагдахгүй

зүйлд итгэхгүй гэдэг. Улмаар зарим хүн гарах үр дагаврыг үл тоомсорлон муу зүйл хийж зүрхэлдэг. Хэчнээн дээд түвшний бурхан ч байсан хүн болж төрвөл, хүний биетэй болбол хүн л гэсэн үг, хүний биед орсон бол төөрөгдөлд орсон гэсэн үг, тиймээс зарим нь төөрөгдлийн дунд нүгэлт үйлийн үрийг бий болгодог. Бүтээгч Гурамсан ертөнцийг бүтээсэн шалтгаан нь амь бодийг зовлон дунд нүглийг нь арилгуулах, хүний ёс суртахууныг дээшлүүлэх үндсэн зорилготой, гагцхүү гэм нүгэлгүй хүмүүс л аврагдаж, диваажин руу буцах боломжтой. Нүгэл үйлдсэн бол түүнийгээ төлөх ёстой, энэ бол сансар ертөнцөд тогтсон хууль. Гэсэн хэдий ч хүн төөрөгдөлд байдаг болохоор энэ хүний орчлонд ахин дахин нүгэл үйлдэх магадлалтай. Тэгэхээр үүнийг мэдээж төлөх ёстой. Энэ насандаа төлөхгүй бол, дараагийн насандаа төлөх болно. Үнэндээ, маш олон хүн маш их нүгэлтэй байдаг. Хүмүүсийг аврахын тулд, Бүтээгч тэдний өмнөөс зовлонгийнх нь зарим хэсгийг үүрдэг. Энэ бол бүх амь бодиудын хувьд хамгийн дээд нигүүлсэл, хамгийн агуу хайр юм. Нүгэлт үйлийн үр нь тодорхой хэмжээнд хүрвэл амь устгагддаг. Нүгэлт үйлийн үрээ арилгаж, тэнгэрт буцах нь чиний энэ дэлхийд ирсний жинхэнэ зорилго юм. Хүн бүр энэ ертөнцөд төрөл олохдоо Бүтээгчид тангараг өргөсөн байдаг. Мэдээж өөрийнхөө нүгэлт үйлийн үрийг төлөхөд маш хэцүү. Үйлийн үр нь хүмүүсийг өөр хоорондоо маргалдаж, тэмцэлдэхэд хүргэдэг, мөн дайн дажин, өвчин эмгэг, хүнд хүчир ажил, өлсгөлөн, ядуурал, улмаар зовлон шаналал үүсгэдэг. Зарим хүн нүгэл ихтэй, зарим нь нүгэл багатай байдаг, чухамдаа их, бага нүглийн улмаас амьдралд баян, ядуугийн ялгаа байдаг. Хэрэв хүн төөрөгдөл дунд ч гэсэн нинжин сэтгэлийг хадгалж байвал, бага үйлийн үр үүсгэнэ! Бага зовно!

Өөрөөр хэлбэл, хүний “төөрөгдөл” нь бүх амь бодиудыг аврахын тулд, агуу сансар ертөнц ба асар олон орчлон ертөнцүүдийг аврахын тулд бий болсон. Энэ “төөрөгдөл”-ийн цаана ийм ноцтой учир шалтгаан байдаг учраас үүнийг хүний сэтгэлд нийцүүлэн эвдэж туйлаас болохгүй. Энэ дэлхий дээр маш олон бурхад, мөнхрөгчид байдаг атал яагаад тэд хүний хүслээр болгодоггүй, төөрөгдлийг эвдэхгүй байна вэ? Тэд ингэж зүрхлэхгүй! Яагаад гэвэл үүнийг Бүтээгч Агуу сансар ертөнцийг болон бүх амь бодиудыг аврах зорилгоор бий болгосон. Энэ бол бүх амь бодиудын авралын найдвар юм!

Багш Ли Хонжи

2024 оны есдүгээр сарын 30